



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 5,000,000,000.00 /таван тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Үндэсний давхар даатгал” ХК /Г.Энхтайван/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

**“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛГҮҮЛСЭН ХӨРӨНГЛИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН**



/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үндэслэл			Өөрчлөлт			Эсгийн үндэслэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэвтрэгсэн үнэ 100 төгрөгөөр/	Дүрмийн санг эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорвогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэвтрэгсэн үнэ 100 төгрөгөөр/	Дүрмийн санг эзлэх хувь
1	Сангийн яам	150,000,000	15,000,000,000.00	100%	50,000,000	5,000,000,000.00		200,000,000	20,000,000,000.00	100%
	Нийт	150,000,000	15,000,000,000.00	100%	50,000,000	5,000,000,000.00		200,000,000	20,000,000,000.00	100%